



МОНГОЛ УЛСЫН  
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Гадаадад сургах тухай

**ТУШААХ НЬ:**

1. Даш-Өлзийн Бадамцэцэгийг АНУ-ын Джорж Вашингтоны Их Сургуульд олон улсын худалдааны менежментийн мэргэжлээр, Мэнд-Ооёогийн Наранбаатарыг ОХУ-ын Бүх Оросын Кино Урлагийн дээд сургуульд телевиз, кино операторын мэргэжлээр, Гэлэгпилийн Лхагвадоржийг АНУ-ын Колумбын дистриктийн Их Сургуульд төрийн удирдлагын мэргэжлээр, Эрдэнэбилэгийн Цэрэннадмидыг АНУ-ын Нью-Йорк хотын Их Сургуульд банкны мэргэжлээр, Өөлдийн Мөнхбатыг Япон улсын Обирины дээд сургуульд олон улсын харилцааны мэргэжлээр тус тус 1998-1999 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.
2. Гэгээрлийн Сайд, Сангийн Сайдын 1998 оны 67/131 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтийн төрийн сангийн захирал Б.Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Алтангэрэлд тус тус даалгасугай.

САЙД

Ч.ЛХАГВАЖАВ

